

Сэдэв: Чингис хаанаас өмнөх үеийн Монголчууд Нэмэлт унших хэрэглэгдэхүүн

Түрэг, Уйгур, Хятан улс, Хар Хятан улс, Алтан улс, Тангуд улс зэрэг Евро-Азийн хүчирхэг нүүдэлчидтэй харьцуулбал монголчуудын дунд хүчирхэг төр улсыг цогцлоон, түүний дор том хэмжээний тогтвортой нийгэм байгуулж чадах тэргүүлэх хүч XIII зуунаас өмнө гарч ирсэнгүй, Энэ үед Монголын тэгш өндөрлөгт түрэг, монгол холилдсон угсаатны олон бүлгүүд *тархай бутархай* оршиж байв. Эдгээрээс хамгийн хүчирхэг нь Монголын тэгш өндөрлөгийн зүүн этгээдэд орших Татар, төв хэсэгт Хэрэйд, баруун этгээдэд орших Найман аймгууд байв.

Татаруудын цөм хэсэг Буйр нуур, Халх голын сав нутагт байсан боловч Хэрлэн мөрний өмнө этгээдэд Хянганы уулс хүртэлх өргөн уудам нутагт Алтан улстай хиллэн нутаглаж байлаа. Тэд тал хээрийн бүсэд улс төрийн түрэмгий, идэвхтэй бодлого явуулдаг байсан юм. Хэдий татар нь Хамаг Монголчуудтай угсаа гарлын холбоотой ч Хамаг Монголыг удирдаж байсан Хабул хааны хүү Охин Бархаг ба Амбагай хааныг Алтан улсад барьж өгч хороолгосон учир Чингисийн өвөг дээдсийн эртний бөгөөд эн тэргүүний дайсан болж байв.

Татаруудын баруун талд *Хэрэйд* аймаг оршиж байв. Тэдний төвлөрөн нутаглаж байсан Сэлэнгэ, Орхон голын хөндий өрнөд, дорнод монголчуудыг холбох зам дээр оршиж байжээ. Мөн тэд монголчуудыг Азийн баруун хэсэг болон Хятадтай холбох худалдааны замд ноёлж байсан юм. Удирдагчид нь XI зууны эхэн үеэс несторины христийн шашинд орсон байв. Баруун талдаа Хар Хятан улс, өмнө талдаа Тангудтай нягт холбоотой байв.

Хэрэйдийн баруун талд Алтайн уулсын өмнөд хэсгээс Эрчим мөрний дээд бэлчир хүртэлх нутагт Найман аймаг оршиж байв. Найманы тэргүүлэх язгууртнууд бөө мөргөл, буддын шашин, несторины христийн шашинтай байсны зэрэгцээ хөрш зэргэлдээ хагас суурьшмал Хар Хятан, Уйгуртай улс төр, соёлын нягт харилцаатай байжээ.

Дээрх гурван гол аймгаас гадна Монголын тэгш өндөрлөгийн умард, өмнө этгээдэд Мэргид, Онгудын улс төрийн нэгдлүүд оршиж байв. Үндсэндээ эдгээр нэгдлүүд улс төрийн сулавтар холбоо байсан тул хожим Тэмүжинд хялбархан дагаар орсон юм. Мэргидийн улс төрийн холбооны мэдэлд Сэлэнгэ мөрний доод бэл, Байгаль нуурын өмнөд тал багтаж байв.


Ойн иргэд ан агнуурт тулгуурлан аж төрдөг нүүдэлчид байв. Тэмүжин улсаа нэгтгэсний дараа тэд Ойрад нэрээр монголын улс төрийн төвд чухал үүрэг гүйцэтгэх болсон юм.

Харин Монголын өмнө этгээдэд *Онгуд, Хонгирад* гэсэн хоёр аймаг нутаглаж байв. Онгудууд IX зуунд Ганьсу, Ордосын нутаг Шар мөрний их тойрог хавьцаа шилжин нутагласан несторины христ шүтлэг давамгайлсан монголжсон түрэг аймаг байлаа. XIII зууны эхэн гэхэд Онгуд нь Алтан улсад алба өргөдөг дагуул улс болсон тул нанхиадын Сүн улс тэднийг цагаан буюу боловсон татарууд хэмээн нэрлэж байсан. Онгудын баруун хойт этгээдээр Хонгирад аймаг Их Хянганы нурууны баруун бэлд нутаглаж байв. Чингисийн байлдан дагууллын дараа тэд Чингисийн шууд үр удам буюу Алтан ургийн ноёдтой худ ураг барилддаг байсан тул монголчуудын их хатдын ихэнх нь энэ овгоос гаралтай байв.

Онон, Хэрлэн, Туул голын сав газар бол монгол туургатны өлгий нутгийн төв бөгөөд монголчуудын гол овог аймгууд төвлөрөн нутаглаж байв. Энэ бүс нутагт оршиж байсан олон жижиг овог, аймгууд VIII-X зууны хооронд Хамаг Монгол нэрт улс төрийн холбоонд нэгдэж байлаа. Хамаг Монгол нь Нукус, Урианхан, Хонгирад зэрэг Дарлиган 16 аймаг, Хатагин, Салжиуд, Монгол, Тайчууд зэрэг Нирун 19 аймгийн нэгдлээс тогтож байлаа.

XII зууны дунд үед Бодончарын удам Боржигин овогтон Хамаг Монголыг тэргүүлж байв. Хабул хааны үед Хамаг Монгол сэргэн мандаж Умард Хятадын Алтан улсын нутаг руу

халдах болжээ. Алтан улс Хабул хаанд өс хонзон санаж, улмаар тэрхүү өшөөгөө Хабул хааныг залгамжлагч, үеэл тайчуудын Амбагай хаанаас татаруудаар дамжуулан авсан байна. Алтан улсын хаан Хабул хааны өс хонзонг авахын тулд түүнийг “модон илжгэнд” төмөр хадаасаар хадан тарчилгаж алав. Амбагай хаан нас барсны дараа хаан орыг залгамжлах хүнээр Хабулын гурав дахь хөвгүүн Хотула сонгогдов. Түүний ачаар Хамаг Монголын удирдлага ахин боржигин овогтонд шилжсэн боловч өст Алтан улс, Татарын эсрэг хийсэн довтолгоо нь төдий л амжилттай болсонгүй. Нас барсных нь дараа Хамаг Монголчуудын дунд тэргүүлэх чадвартай удирдагч тодорсонгүй, Хабул, Амбага, Хотула хаад хэдий удирдах чадвараараа тэргүүлж байсан ч тэдний байгуулсан улс төрийн нэгдэл задарч эхлэв. Яг энэ үед Тэмүжин төржээ. Чингис хааны эцэг Есүхэй бол Хабул хааны хоёр дахь хөвгүүн, Хотула хааны ах Бартан Баатарын гуравдугаар хөвгүүн байв. Түүний үед монголчуудын нэг хэсэг Алтан улс, нөгөө хэсэг Татар луу уулгалан дайрах, эсвэл өөр хоорондоо өрсөлдөн тэмцэлдсэн улс төрийн байнгын тогтворгүй нөхцөл бүрэлдсэн байжээ.



Ашигласан материал

- “Монголын түүх X” сурах бичиг, УБ., 2017.
- Е.ред П. Дэлгэржаргал нар “Монгол Улсын түүх” УБ., МУИС пресс.
- Ц. Гантулга нар “Багшийн ном” УБ., 2019